



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 78 дугаар зүйлийн 78.2.4, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны 04 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1617 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийн гэр, амины орон сууцны халаалтын эх үүсвэрийг хийн түлшний хэрэглээнд шилжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн 7, 9, 10, 11, 12, 13, 15, 16, 20, 21, 22 дугаар хороонд байгуулах Хийн түлшний борлуулалтын цэгийг холбогдох эд хөрөнгийн хамт хүлээж авах, борлуулагчид хүлээлгэн өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч:

Дүүргийн менежер

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх тасгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Гэрэлтүүлэг, реклам сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Таван толгой түлш ХХК-ийн Төслийн удирдлагын хэлтсийн Ахлах инженер Б.Батбилэг /зөвшилцсөнөөр/

Таван толгой түлш ХХК-ийн Төслийн удирдлагын хэлтсийн Дулааны инженер Б.Ууганбаяр /зөвшилцсөнөөр/


Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн
тасгийн Өмчийн нягтлан бодогч

2.Ажлын хэлтсийн үйл ажиллагааны явц, үр дүнг тухай бүр танилцуулахыг
ажлын хэсэг (Д.Уянга)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч
(Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the ministry and department. The signature is stylized and extends across the stamp.

Н.МАНДУУЛ